

№	Нэр, имейл хаяг	Санал, хүсэлт
1.	О.О	Сайн байна уу? Энэхүү хуулийн төслийн 35-р зүйлд заасанчлан хяналт шалгалтын байгууллагын тогтолцоонд хилийн боомтуудын мэргэжлийн хяналтыг гаалийн байгууллагаас салгах шаардлагатай. Учир нь хэрэгжүүлэх чиг үүрэг нь тэс өөр байгууллагууд нэгдсэнээр хяналтын чанар, цаашилбал улс үндэстний аюулгүй байдал алдагдахад хүрч байна.
2.	Д.Д	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.3.-д хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт гэснийг дараах байдлаар өөрчлөн найруулах саналтай байна. <b>14.1.3. Хөдөлмөрийн хяналт</b> гэж өөрчлөх.
3	Ж.Б	<p>1.“Хуулийн төсөл боловсруулах үзэл баримтлал”-ын “1.1.Хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл, шаардлага” хэсэгт “16 дугаар зүйлийн 4 дэх заалтад ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж нэмж оруулах.</p> <p>2. 4.1.9.“улсын байцаагч” гэж хуульд заасны дагуу хяналт шалгалт болон зөрчлийн хэрэг бүртгэл явуулах эрх бүхий албан тушаалтныг;</p> <p>3. 6.2.Тандан судалгааг эрсдэлийн шинжилгээ, шинжилгээт шалгалтын хэлбэртэй байх бөгөөд төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ.</p> <p>4. 19.2.3.гүйцэтгэлийн шалгалтын удирдамжийг Засгийн газрын Хяналтын ерөнхий газрын нэгжийн дарга, эсхүл хяналт шалгалтын байгууллагын дарга.-<b>Хасах</b></p> <p>5. 14.1.3 дахь заалтад хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хяналт гэж өөрчлөх</p> <p>6. 19.3.Хяналт шалгалт хийх бүрт хяналтын хуудсыг удирдамжийн хавсралтаар батлуулна. Гэж өөрчлөх</p> <p>7. 26.1.Хяналт шалгалтын явцад Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил илэрсэн аж ахуйн нэгж байгууллага нь хяналтын хуудсаар эрсдэл бага гэж үнэлэгдсэн бол уг зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлж болно. Гэж өөрчлөх</p>
4	А.Т	Хуулийн төслийн хяналтын чиглэлүүдэд багтаагүй байгаа дараах хяналтын чиглэлүүд байна. Эдгээрийн зайлшгүй хяналтын байгууллагын нэгдсэн бүтцэд байлгах шаардлагатай гэж үзэж байна. <ol style="list-style-type: none"> <li>1. <b>Эрүүл ахуйн хяналтууд.</b></li> <li>2. <b>Хилийн хяналт</b></li> <li>3. <b>Нийгмийн хамгааллын хяналт</b></li> <li>4. <b>Авто замын хяналт</b></li> </ol>

5	Ц.Ц	Боловсролын хяналтыг төрийн хяналтаас гаргаж байгаа нь Боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхээс ухарч байна гэж үзэж байна . Ийм д боловсролын хяналтыг Төрийн хяналтад хэвээр үлдээх саналтай байна.
6	С	Энэ хуулийн төсөлд 14-р заалтын 14.1-д Цаашид зам, тээврийн салбарын хяналт байх нь зүйтэй, түүнчлэн хяналт шалгалтын шаардлага яаж өөрчлөх, Улсын байцаагчийн хийх ажил, гарах үр дүн, эрхийг яаж хамгаалах уу?
7	Д.Н	"Төр иргэний хяналт шалгалтын тухай" хуулийн төслийн 14.1-д боловсролын хяналтыг нэмэх саналтай байна. Боловсролын хяналт төрийн хяналтад байх нь чухал байна.
8	Б	Соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналтыг ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар хийх ёстой, төрийн хяналтад байх нь чухал байна.
9	Х	14.1-д боловсролын хяналтыг нэмэх, боловсролын хяналт төрийн хяналтад байх нь чухал.
10	Ц.И	Хуулийн төслийн 14 дүгээр зүйл.Хяналт шалгалтын хүрээ хэсэгт дараах асуудлыг нэмэх 14.1.1 дэх заалтад "эрүүл мэнд, эм, био бэлдмэлийн чанар, аюулгүй байдлын хяналт" гэснийг "эрүүл мэнд, эрүүл ахуй, эм, био бэлдмэлийн чанар, аюулгүй байдлын хяналт" гэж өөрчлөн найруулах Үндэслэл: Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.1-д "эрүүл мэнд" гэж хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг гэж тодорхойлсноор эрүүл мэнд нь "хүн" эрүүл байх тухай ойлголт юм. Харин Эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.1-д "эрүүл ахуй" гэж хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчноос шалтгаалан эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг тандах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нөхцөл, шаардлагыг; гэж тодорхойлсноор эрүүл ахуй нь хүн оршин байх газар нутаг, орон байр, эдэлж хэрэглэх эд зүйл, үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангуулах тухай ойлголт юм. Иймд хуулийн төслийн дээрх заалтад "эрүүл ахуй" гэсэн агуулгыг нэмэлтээр оруулах зайлшгүй шаардлагатай байх бөгөөд "Эрүүл мэнд" гэдэгт "эрүүл ахуйн" ойлголтыг нэгтгэн ойлгох боломжгүй юм.
11	А	Өглөөний мэнд 14.1-д Боловсролын хяналтыг нэмэх. Учир нь боловсролын салбар төрийн хяналтад байх шаардлагатай.
12	Д.Х	Хэмжил зүйн хяналтыг Засгийн газрын Хяналтын Ерөнхий газар хийж гүйцэтгэх саналтай байна.

13	Б	Хяналтын чиглэл дээр / Хэмжил зүйн хяналт/-ыг оруулах саналтай байна. Энэхүү хяналт нь Хэмжил зүйн тухай хууль, Стандартчлал тохирлын үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хүрээнд Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж буй ус, дулаан, цахилгаан, шатахуун түгээгүүр, уул уурхай, байгаль орчин, эрүүл мэндийн тоног төхөөрөмжүүд, хэмжих хэрэгслүүд, хүнсний хэмжүүрүүдэд хэмжих хэрэгслүүд гэх мэт бүх салбарт хяналт тавигддаг салбар мөн тул тус хяналтыг оруулах саналтай байна.
14	Б	Боловсрол, соёлын хяналтыг Засгийн Газрын Хяналтын ерөнхий газарт харъяалуулах саналтай байна.
15	Б.С	Олон нийтээр хэлэлцүүлж буй <b>ТӨР-ИРГЭНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ-ийн 14.1 дүгээр хэсэгт Боловсролын хяналтыг нэмэх, боловсролын хяналт нь төрийн хяналтад байх чухал гэдгийг илэрхийлье.</b>
16	У.Х	"ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА"-ЫН 14 ЗҮЙЛ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХҮРЭЭ 14.1 Дараах чиглэлийн хяналт шалгалтыг Засгийн газрын Хяналтын Ерөнхий газар хийж гүйцэтгэнэ гэсний 14.1.7 боловсролын хяналтыг нэмэх 14.3 Дараах чиглэлийн хяналт шалгалтыг мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно гэсний 14.3.1 боловсролын хяналт хасах Үндэслэл нь Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 .Боловсролын хяналт шалгалтыг холбогдох хуульд заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалтын улсын байцаагч хэрэгжүүлнэ гэсэн байдаг.
17	Ш.Б	Тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "боловсролын хяналт"-ыг нэмж оруулах. Учир нь боловсролын салбар нь том салбар ба боловсролын хяналт төрийн хяналтад байх нь маш чухал. Боловсролын салбарт төрийн хяналт алдагдаснаар боловсролын чанар муудах, чанаргүй цэцэрлэг, ЕБС, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургууль бий болох, чанаргүй боловсон хүчин бий болох, сургууль, цэцэрлэгийн стандартууд алдагдах, эрсдэл бий болох аюултай.
18	А.У	Боловсролын салбар нь нэн тэргүүнд тавигдах улс орны тэргүүлэх салбаруудын нэг юм. Иймд тус салбарт хяналтын тогтолцоог хэвээр байлгах нь төрийн үйл ажиллагааны нэг хэсэг. --Боловсролын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлд- БОЛОВСРОЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭГ дараах байдлаар тусгасан байдаг. 35.1.Боловсролын хяналт шалгалтыг холбогдох хуульд заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

		<p>35.2.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын улсын байцаагч боловсролын болон холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавина.</p> <p>Иймээс тус хуулийн ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ ЖУРАМ 14 дүгээр зүйл. Хяналт шалгалтын хүрээ 14.1.7 дахь хэсэгт нэмэлтээр <b>боловсролын хяналтыг</b> зайлшгүй оруулах нь зүйтэй юм.</p>
19	Ж.Ш	<p>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 38 дугаар зүйлд "Засгийн газрын Хяналтын ерөнхий газар, аймаг, дүүргийн хяналтын газрын улсын ахлах, улсын байцаагч нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба хаагч мөн"- гэсэн санал оруулах.</p>
20	М.Д	<p>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 38 дугаар зүйлд "Засгийн газрын Хяналтын ерөнхий газар, аймаг, дүүргийн хяналтын газрын улсын ахлах, улсын байцаагч нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба хаагч мөн"- гэсэн санал оруулах.</p>
21	А	<p>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай танилцлаа.</p> <p>Тус хуулийн 14 дүгээр зүйлд Хяналт шалгалтын хүрээ:</p> <p>14.1.Дараах чиглэлийн хяналт шалгалтыг Засгийн газрын Хяналтын Ерөнхий газар хийж гүйцэтгэнэ гэж заасан байна.</p> <p>14.1.3.хөдөлмөрийн аюулгүй байдал,</p> <p>14.1.5.<b>барилга, эрчим хүчний хяналт зэрэг хяналтууд</b> нь нийслэл аймаг, орон нутагт тусдаа төсөв, санхүүжилттай салбар хороодтой. Жич: Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Барилгачдын холбоо зэргийг нэрлэж болно.</p> <p>Гэвч дээрх чиглэлүүдийг хуулийн 14.3-д зааснаар бусад хяналтын чиг үүргийг орон нутагт гүйцэтгүүлэх эрх бүхий салбар чиглэлийг “мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно” гэж заасан <b>заалтад хамааруулаагүй бусад салбарын хяналтын чиглэлээс ялгаваралтай байдлаар оруулсан нь зөрчигдсөн байна гэж үзэж байна.</b></p> <p>Жич: Мэдээлэл, харилцаа холбооны хяналт, Авто замын хяналтыг дээрхтэй адил гэж үзэж байгаа тул 14.1- дэх заалтаар хуулинд тусгаж оруулах./ Эрчим хүчний шугам сүлжээ, харилцаа холбооны шугам сүлжээ адилхан дэд бүтэц/ .</p> <p>14.3.5.эрсдэл багатай гэж үнэлэгдсэн бусад чиглэлийн хяналт.- <b>энэ заалтад ямар чиглэлийн хяналтыг авч үзэх - Тодорхой нэршил зааж өгөх</b></p> <p>Төрийн хяналт нь өөрөө хөндлөнгийн хяналт байх тул мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжгүй гэж үзсэн. .</p>

22	С.Н	<p>14 дүгээр зүйл.Хяналт шалгалтын хүрээ:  14.3.Дараах чиглэлийн хяналт шалгалтыг мэргэжлийн нэгдсэн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно:  14.3.1.боловсролын хяналт;  14.3.2.автозам, авто тээврийн хяналт;  14.3.3.соёл, соёлын өв, аялал жуулчлалын хяналт;  14.3.4.мал үржүүлэг, технологийн хяналт;  14.3.5.эрсдэл багатай гэж үнэлэгдсэн бусад чиглэлийн хяналт гэсэн байна. Үүнд бид Мэргэжлийн хяналтын байгууллагаас Засгийн газрын тогтоолоор салбар яамандаа шилжин ажиллаж байна. 14.3.2.автозам, авто тээврийн хяналтыг 14.1.Дараах чиглэлийн хяналт шалгалтыг Засгийн газрын Хяналтын Ерөнхий газар хийж гүйцэтгэнэ: гэсэн заалтруу нэмэх саналтай байна. Учир нь Зам, тээврийн хяналт бол хүний амь нас, хүрээлэн буй орчин шууд хамааралтай чухал салбар юм. Уул уурхай, байгаль орчин, барилга эрчим хүч гээд бүх салбарт тээвэр хамааралтай салбар дундын хяналт гэж явдаг. Аюултай ачаа тээвэрлэлтээс эхлээд заавал төрийн хяналтад хамаарах нэн чухал тул энэ салбарын хяналтын улсын байцаагчдын эрхзүйн байдлыг дордуулахгүй хуучин бүтэц болох дэд бүтэц гэх нэршилээр нь байгуулах шаардлагатай гэж Улсын байцаагч миний бие үзэж санал хүргүүлэв. Хүлээн авч бидний эрх ашигыг хамгаална гэж найдаж байна.</p>
23	Г.Б	Төрийн өмнөөс хийх шалгалтын төрийн бус байгууллага, холбоод хийж болохгүй.
24	Р.Х	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-д хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт гэснийг <b>“Хөдөлмөрийн хяналт”</b> гэж ерөнхий нэршлээр нь өөрчлөн, хөдөлмөрийн болон нийгмийн хамгааллын хяналтыг хамтад хэрэгжүүлэн, ажилтны хөдөлмөрлөх эрхийг бүрэн хангуулах шаардлагатай байна.
25	Б.З	<p>1.5.1.2.хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх, сурч боловсрох, нийгмийн болон хүрээлэн буй орчин, техник, технологийн аюулгүй байдал нь бусад аливаа ашиг сонирхол, зорилгоос илүүд байх; гэж нэмэх  2. 14.1.7 Хэмжил зүйн хяналт гэж нэмэх  3. Эрсдэл багатай бусад чиглэлийн хяналтаас хэмжил зүйн хяналтыг хасах.</p>
26	Б.У	<p>1.Боловсролын хяналт өмнөх болон одоо байгаагаасаа юугаараа шинэлэг, онцлог байх ёстой вэ?  МУ-ын боловсролын салбар өнөөдөр чанарын ялгаа, хүртээмжийн зөрүү, багшийн ачаалал, сургалтын орчны аюулгүй байдал зэрэг олон бодит сорилттой тулгараад байна. Хот хөдөөгийн сургалтын чанарын зөрүү тэлж, анги дүүргэлт хэт их, байгууллагын дотоод хяналт, өөрийн үнэлгээ бодит бус байх хандлага нийтлэг байдаг.</p>

		<p>Эдгээр нөхцөл байдал нь боловсролын хяналтыг өмнөх болон одоогийн хэлбэрээр үргэлжлүүлэхэд бодит үр дүн багатай байгааг харуулж байна.</p> <p>2. Боловсролын хяналт яагаад төрд байх ёстой гэдгийг гаргаж өгөх.</p> <p>3. Улсын байцаагч эрх зүйн баталгаа:</p> <p>Боловсролын хяналтын улсын байцаагч нь хүүхдийн эрх, сургалтын чанар, аюулгүй байдал, тэгш хүртээмжийг хангах төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч албан тушаалтан. Гэвч практикт тэдний хараат бус байдал, мэргэжлийн шийдвэр гаргах эрх, нийгмийн болон эрх зүйн баталгаа хангалтгүйгээс хяналтын үр нөлөө сулрах, гадны нөлөөнд өртөх эрсдэл байсаар байна. Иймд боловсролын хяналтын улсын байцаагчийн эрх зүйн баталгааг хамгийн өндөр түвшинд буюу хуульд шууд тодорхой тусгах шаардлагатай.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хараат бус байдлын баталгааг хуульчлах</li> <li>2. Албан тушаалын тогтвортой байдлын баталгаа</li> </ol> <p>Бие даасан шийдвэр гаргах эрхийг баталгаажуулах</p>
27	Ц.М	<p>1.14.1.7 Хэмжил зүйн хяналт гэж нэмэх</p> <p>2. Хуулийн төслийн 10.4-т гүйцэтгэлийн шалгалтыг улсын байцаагчийн өгсөн эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлсэн эсэхэд хийж гүйцэтгэнэ гэсэн тул дахин шинээр удирдамж боловсруулан шалгалт хийх нь иргэн, аж ахуйн нэгжид дарамт мэт ойлгогдож хүндрэл бэрхшээл үл ойлголцол үүсэхээр харагдаж байна. Тийм учраас дахин удирдамж боловсруулах шаардлагагүй гэсэн саналтай байна. Мөн улсын байцаагч удирдамж батлах эрх бүхий субъект биш юм.</p> <p>3.Хуулийн төслийн 28.4-т заасан “арга хэмжээ авна” гэсэн ерөнхий томъёолол нь практикт торгууль шууд оногдуулах байдлаар хэрэглэгдэх эрсдэлтэй байна. Үүний улмаас:</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Байцаагчийн субъектив шийдвэр давамгайлж,</li> <li>○ иргэн, ААН-д шаардлагагүй дарамт үүсч,</li> <li>○ хууль ёсны шаталсан арга хэмжээ (анхааруулга, албан шаардлага, хугацаатай үүрэг) хэрэгжих боломж багасна.</li> </ul> <p>Иргэд, байгууллага нь хуульд заасан шаталсан арга хэмжээг мэдэлгүй шууд торгуулийн эрсдэлд орно. Үүний улмаас зөрчлийн шинж, давтамж, санаатай эсэхийг харгалзах боломжгүй болж иргэний эрхийн баталгаат хамгаалалт алдагдах эрсдэлтэй.</p>
28		<p>1.Хуулийн төслийн 14.1-т Барилга байгууламжийг дагалдан хийгдэх бусад хяналтын орхигдуулсан ус дулаан, эрчим хүч, харилцаа холбооны инженерийн байгууламж/ гэж авч үзлэг. Үүнээс ганц барилга, эрчим хүч гэж онцгойлон авч ялгавартай байдлаар тусгасан нь өөрөө өрөөсгөл.</p>

		<p>Тусгайлан авч оруулсан барилга, эрчим хүчний хяналт нь өөрөө “Төрийн хяналт шалгалт” нэрийдлээр хясан боогдуулах, хяналт шалгалтын дарамтыг бууруулж, давхардсан хяналтыг арилгах бус орон нутагт харин ч эсрэгээрээ байх магадлалтай. /Ашиг сонирхлын зөрчил үүсэх өндөр эрсдэлтэй салбар /. Үүнийг дахин ард иргэдийн санал асуулгаар хэлэлцүүлэх.</p> <p><b>2.</b> Барилга байгууламж, эрчим хүчний хяналт--Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Орон нутагт түүний харьяа байгууллага,, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, орон нутгийн зохицуулах зөвлөл, бусад , мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж болно.</p> <p><b>3.Байгаль орчин, уул уурхай, цөм цацрагийг хасах</b>--Мэргэжлийн холбоо, , Байгаль орчны газар, бусад ТББ- аар нэгэн адил гүйцэтгүүлж болно. /Ашиг сонирхлын зөрчил үүсэх өндөр эрсдэлтэй салбар/.</p> <p>4. 14.3.5.эрсдэл багатай гэж үнэлэгдсэн бусад чиглэлийн хяналт.-- Мэдээлэл, харилцаа холбооны хяналтыг “бусад” гэсэн ерөнхий ангилалд оруулж байгаа нь салбарын онцлог эрсдэлийг бүрэн тусгаагүй байна. Жич: Салбарын хяналтын хуудсанд багтаагүй боловч эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлдэг техник, технологийн ажиллагааг үнэлгээнд оруулахгүй орхигдуулсан нь зохицуулалтыг сулруулж байна.</p>
29	Т	<p><b>ТӨР-ИРГЭНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ</b> /Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга/ -ын дүгээр зүйлийн 14.3.4. Мал үржүүлэг, технологийн хяналтыг холбоо, тбб хийхээр оруулсан байгаа нь Малын генетик нөөцвийн тухай хуулийн зохих заалтуудыг ноцтогйоор зөрчиж байгаа тул хуулийн төсөлд Төрийн байгууллага хяналтаа хийх цаашлаад 14.1.7-д Мал үржүүлэг, технологийн хяналтыг оруулах санал өгч байна.</p> <p>Монгол малын генийн сан, монгол улсын хүнсний хангамж, аюулгүй ажиллагаатай холбогдож байгаа уг салбарыг ЭРСДЭЛ багатай ангилалд оруулж байгаа нь өөрөө ихээхэн ЭРСДЛИЙГ нөхцөлдүүлж болохыг анхаарч үзнэ үү.</p>